



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/183

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн харьяат залуу уран бүтээлч дуучин Гантулгын Даваадалайн “Мартагдашгүй” аялан тоглолтын дэмжлэгт 400,000 төгрөг, Хөгжимт драмын театрын жүжигчин Баасандоржийн Бямбасүрэнгийн “Төгсгөл” уран сайхны киноны нээлтэнд 500,000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Арга хэмжээнд зарцуулагдах 900,000 төгрөг (Есөн зуун мянга)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.4-д тусгагдсан “Олон үндэстэн ястны өв соёл урлаг” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ